

**ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2023 оны 08 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг танилцуулж байна.

**НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

**1.1. “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт:**

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тус хүрээлэнгээс хэрэгжүүлэх 1 зорилтын хүрээнд 2 арга хэмжээ туссан бөгөөд 2023 оны эхний хагас жилд хэрэгжүүлэхээр байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан. Байгууллагын хэрэгжүүлэх 2 арга хэмжээний биелэлтийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар үнэлэхэд хэрэгжилт 100 хувьтай байна.

№	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь				Дундаж	
		100	70	50	30	хувь	оноо
1	2	2	-	-	-	100	5

*/Биелэлтийг хавсралт 1-ээс үзнэ үү/*

**1.2 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт.**

“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 4.4.4, 4.4.7, 4.4.9 зорилтын хүрээнд 6 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллажээ.

Хөтөлбөрийн 6 арга хэмжээний хэрэгжилтийг хүснэгтээр үзүүлбэл:

№	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь				Дундаж	
		0	40	90	100	хувь	оноо
1	6	1	-	-	5	83.3	4.2

*Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ, шалтгаан нөхцөл:*

- “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, ял хариуцлагыг нэмэгдүүлэх, мансууруулах донтой этгээдэд эрүүл мэндийн тусламж үзүүлэх, эрт шатанд нь илрүүлэх, эмчлэх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор холбогдох хуулийн төслийг боловсруулж, Улсын их хуралд өргөн мэдүүлнэ” арга хэмжээний хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас чиглэл ирүүлээгүй болно.

*/Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хавсралт 2-оос үзнэ үү/*

### **1.3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт**

№	Тогтоолын дугаар	Арга хэмжээний тоо	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь				Дундаж	
			0	30	70	100	хувь	оноо
<b>Статистикийн тухай хууль</b>								
1	11.6. Яам, Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллага, нутгийн захиргааны байгууллага чиг үүргийнхээ дагуу статистикийн үйл ажиллагааг эрхэлнэ. Яамд бүтэцдээ салбарын статистикийн үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэх нэгжтэй байна.	14	-	-	-	14	100	5
2	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2016-11-03 Дугаар 2016 №51, 2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан, холбогдон гарах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Авлигатай тэмцэх газар /Х.Энхжаргал/-т тус тус даалгасугай.	1	-	-	-	1	100	5
<b>Нийт</b>		15	-	-	-	15	100	5

Тайлант хугацаанд 1997.06.05. Статистикийн тухай /Шинэчилсэн найруулга/ / 1997-06-05 / МУ-ын хууль”-ийн хүрээнд статистик мэдээг 2 удаа, инфографик мэдээг 7 удаа сар бүр тогтмол гаргаснаар иргэдийг хялбар аргаар байгууллагын үйл ажиллагаатай танилцах боломжоор хангаж, байгууллагын үйл ажиллагааны инфографик мэдээг сар бүрээр нэгтгэн:

- 01.05-нд 01/04 тоот албан бичиг,
- 02.03-нд 01/66 тоот албан бичиг,
- 03.03-нд 02/96 тоот албан бичиг,
- 04.06-нд 03/131 тоот албан бичиг,
- 05.09-нд 01/197 тоот албан бичиг;
- 06.06-нд [ariunjargal@mojha.gov.mn](mailto:ariunjargal@mojha.gov.mn) цахим хаягаар,
- 07.07-нд [ariunjargal@mojha.gov.mn](mailto:ariunjargal@mojha.gov.mn) цахим хаягаар байгууллагын статистикийн мэдээг ХЗДХЯ-нд тус тус хүргүүлсэн.

*/Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг хавсралт 3-аас үзнэ үү/*

## ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

### 2.1. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт.

Хууль зүйн үндэсний хүрээлэн нь 2023 онд дэвшүүлсэн 5 зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусган эхний хагас жилд 46 арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Үүнээс хариуцсан чиг үүргээр авч үзвэл:

№	Үндсэн чиг үүрэг	Арга хэмжээний тоо	Арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ /хувиар/						Хэрэгжилт /хувиар/
			100	90	70	50	30	0	
1	Үндсэн чиг үүрэг №1. /ХЗҮХ-гийн “2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”, зорилт 1/	4	4	-	-	-	-	-	100%
2	Үндсэн чиг үүрэг №2. /ХЗҮХ-гийн “2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”, зорилт 2/	3	3	-	-	-	-	-	100%

3	Үндсэн чиг үүрэг №3. /ХЗҮХ-гийн "2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө", зорилт 3/	15	15	-	-	-	-	-	100%
4	Үндсэн чиг үүрэг №4. /ХЗҮХ-гийн "2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө", зорилт 4/	17	17	-	-	-	-	-	100%
5	Үндсэн чиг үүрэг №5. /ХЗҮХ-гийн "2021- 2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө", зорилт 5/	7	7	-	-	-	-	-	100%
Нийт		46	46	-	-	-	-	-	100%

Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган эхний хагас жилд 46 арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллах бөгөөд 46 арга хэмжээ 100% хувийн хэрэгжилттэй тодорхой үр дүнд хүрсэн байна.

## **2.2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр**

### **А.Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх**

**А.1.** Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт зохион байгуулах хөтөлбөрийн хүрээнд 2023 оны эхний хагас жилийн байдлаар 6 үндсэн сэдвийн хүрээнд 10 удаагийн дотоод сургалт зохион байгуулсан байна.

Хэрэгжилтийг хүснэгтээр үзүүлбэл:

№	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь				Дундаж	
		0	40	70	100	хувь	оноо
1	6				6	100	5

Байгууллагын 2023 оны дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу албан хаагчдад:

1. Хууль тогтоомжийн тухай хуулийн талаар /шинэчилсэн найруулга, нэмэлт өөрчлөлт/ нийт албан хаагчдад 1 удаагийн дотоод сургалт, хамрагдсан албан хаагч 21,
2. Албан хэрэг хөтлөлтийн "edoc" системийн талаар нийт албан хаагчдад 1 удаагийн дотоод сургалт, хамрагдсан албан хаагч 21,
3. Спортын арга хэмжээний хүрээнд спорт, сургалтын сэдвээр нийт албан хаагчдад 1 удаагийн дотоод сургалт, хамрагдсан албан хаагч 6,

4. "Алсын хараа 2050" сэдвээр нийт албан хаагчдад 1 удаагийн дотоод сургалт, хамрагдсан албан хаагч 16,
5. Эрүүл мэндийн сэдвээр нийт албан хаагчдад 1 удаагийн дотоод сургалт, хамрагдсан албан хаагч 24,
6. Албан хаагчдыг дэмжих, хөгжүүлэх сэдвээр сургалт нийт албан хаагчдад 1 удаагийн дотоод сургалт, хамрагдсан албан хаагч 11,

Үүнээс мэргэшүүлэх сургалт:

1. **03.23-нд** НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх газраас зохион байгуулагдсан "Статистикийн зорилгоор гэмт хэргийн олон улсын ангилал (ICCS) болон гэмт хэргийн хохирогчийн судалгаа (CVS)-ийн хэрэгжилтийн талаарх сургалт"-д амжилттай хамрагдсан ХЗҮХ-ийн албан хаагч 2 ЭША,
2. **04.26-нд** МУЗГ, Жендерийн үндэсний хорооноос зохион байгуулагдсан "Жендер ба бодлого төлөвлөлт, анхан шатны сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан сургагч багш бэлтгэх сургалт"-д амжилттай хамрагдсан ХЗҮХ-ийн албан хаагч 1,
3. **04.27-нд** ХЗҮХ-ээс зохион байгуулагдсан "Хууль зүйн англи хэлний сургалт"-д амжилттай хамрагдсан ХЗҮХ-ийн албан хаагч 7 ЭША, тус тус хамрагджээ.

**А.3. Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хүрээнд:**

1. Тайлант хугацаанд 4 албан хаагч шинээр ажилд авч хөдөлмөрийн гэрээ байгуулсан, өөр албан тушаалд шилжин ажилласан 3, ажлаас гарсан 8, гадаадын их дээд сургуульд суралцаж байгаа 2, жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй 6, гэрээт албан хаагч 5 байна. Холбогдох мэдээллийг хүний нөөцийн нэгдсэн системийн програмд тус тус оруулсан.

#### **Б. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах**

1. Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь нь тайлант хугацаанд 34.8% хувийг зарцуулсан байна.
2. Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдлийг тайлант хугацаанд нийт 1 242 000 төгрөгийг зарцуулж, тухай бүр олгож ажилласан.
3. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Монгол Улсын "Алсын хараа 2050" урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт "Эрүүл дадал хэвшилтэй идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн Эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ гэх зорилтыг дэвшүүлж, үндэсний хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх зорилгоор ЭМЯ-наас 2022 оныг "Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах" жил болгон зарлаж, 2023 оны 5-р сарын 1-ний өдрөөс орон даяар хэрэгжүүлэх ажлын дагуу "Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг"-тэй хамтран 12 албан хаагчийг "Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ"-нд хамруулсан байна.

5. Албан хаагчдын нийгмийн асуудалд тайлант хугацаанд 197 600 мянган төгрөг зарцуулсан.

*/Төлөвлөгөөний биелэлтийг хавсралт 6-аас үзнэ үү/*

### **2.3. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ**

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу нийт 13 шалгуур үзүүлэлтээс тус хүрээлэнд шууд хамааралтай 11 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг гаргаж ил тод байдлын үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

Үнэлгээг хүснэгтээр үзүүлбэл:

№	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	Үнэлгээ /хувиар/				Дундаж	
		100	70	30	0	хувь	оноо
1	11	11	-	-	-	100	5

*/Ил тод байдлын үнэлгээг хавсралт 7-оос үзнэ үү/*

#### **2.3.1. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлын талаар:**

Мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор байгууллагын албан ёсны цахим хуудас болон олон нийтийн сүлжээг хөтлөн мэдээ, мэдээллийг цаг тухайд нь байнга шинэчлэн ажилласан байна. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн албан ёсны цахим хуудас болох [www.nli.gov.mn](http://www.nli.gov.mn) цахим хуудасны танилцуулга буланд байгууллагын үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, байгууллагын танилцуулга, бүтэц, 2023 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн зэргийг байршуулсан.

Хүрээлэнгийн мэдээллийн самбар, цахим хуудас, <https://nli.gov.mn/>, фэйсбүүк хуудас [www.facebook.com/NLInstitute](https://www.facebook.com/NLInstitute), твиттер хуудас [twittercom/legalinstitute](https://twitter.com/legalinstitute)-д байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээлэл болон холбогдох хууль тогтоомжийг тогтмол шинэчлэн байршуулж мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан.

Иргэдийн санал, хүсэлт, гомдол, мэдээллийг байгууллагын 11-315-735 утас, байгууллагын албан ёсны цахим хуудас <https://nli.gov.mn/>, хүрээлэнгийн нэгдүгээр давхарт байршуулсан санал хүсэлтийн хайрцгаар тус тус дамжуулан хүлээн авсан байна.

Мөн өөрийн байгууллагын цахим хуудсанд үйл ажиллагаандаа мөрдөж хэрэгжүүлдэг хууль тогтоомж, дүрэм, журмыг байршуулсан бөгөөд тус хүрээлэнгээс үзүүлж буй үйлчилгээний нэр төрөл, төлбөрийн талаарх мэдээллийг шинэчлэн байршуулжээ.

***/Үнэлгээ 100 хувь/***

### **2.3.2. Хүний нөөцийн ил тод байдлын талаар:**

Хүний нөөцийн ил тод байдлыг хангах зорилгын хүрээнд байгууллагын цахим хуудас болох <https://nli.gov.mn/> цахим хуудсанд Хөдөлмөрийн дотоод журам, Хүний нөөцийн бодлогын баримт бичиг, Албан хаагчийн ёс зүйн дүрэм, Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам болон хүний нөөцийн сул орон тооны талаарх зарыг тухай бүр байршуулж, нийтэд мэдээлэл өгч ажилласан байна.

Хүний нөөцийн бүрдүүлэлтийн программд холбогдох мэдээллийг тухай бүр шинэчлэн оруулан, хувийн хэргийн баяжилтыг тогтмол гүйцэтгэж ажилласан. **/Үнэлгээ 100 хувь/**

### **2.3.3. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ**

Тус хүрээлэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд байгууллагын санхүүгийн тайланг Шилэн дансны нэгдсэн портал сайт болон маягтын дагуу байгууллагын цахим хуудаст байршуулсан байна.

Тус хүрээлэнгийн <https://nli.gov.mn/> цахим сайтын Шилэн данс цонхонд байгууллагын жилийн төсөв, 2022 оны төсвийн гүйцэтгэл, 2023 оны төсвийн төсөл, санхүүгийн аудитын тайлан зэргийг байршуулсан.

Шилэн дансны тухай хуулийн 5.1.1, 5.1.2, 5.1.3, 5.1.4 дэх хэсэгт заасан шаардлагыг ханган ажилласан байна.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд нийт 58 мэдээ оруулсан байна.

## **ГУРАВ. ДҮГНЭЛТ**

Тайлант хугацаанд байгууллагын 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, “Алсын хараа 2050” бодлогын баримт бичиг, Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Мэдээллийн ил тод байдал, Шилэн дансны хөтлөлт зэрэг үзүүлэлтээр байнгын хяналт тавин улирал, хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, зөвлөмж гарган ажилласан. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам”-д заасны дагуу Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг дүгнэвэл:

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт	100%	0.6	5
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	83.3%		4.2
	3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	100%		5
	4. Салбарын хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	-		-
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	100%	0.2	5
	2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	100%		5
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	100%	0.2	5
	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	98.3%		4.9
	3. Шударга байдлын түвшний үнэлгээ	-		-
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	-		-
<b>Ерөнхий үнэлгээ:</b>		<b>82.2</b>	<b>1.0</b>	<b>4.11</b>

Шударга байдлын үнэлгээг АТГ-аас гаргадаг, Хэрэглэгчийн үнэлгээг ЗГХЭГ нэгдсэн байдлаар үнэлгээ хийдэг.

Ерөнхий үнэлгээ хийсэн аргачлал:

$$E=0.05*[(100+83.3+100+0)]/4*0.6+(100+100)/2*0.2+(100+98.3)/2*0.2]=0.05(42.4+20+19.83)=4.11$$

### ДӨРӨВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 50 дугаар тогтоолоор “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан ба хөтөлбөрийг хэрэгжүүлэх, салбар дундын уялдааг хангах Үндэсний Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг тус хүрээлэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн цахим мэдээллийн сан "e-khutuch.mn" портал цахим хуудас, "Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн 1800-1202 тусгай дугаар", "Хууль зүйн үндэсний хүрээлэн" фэйсбүүк, legalinstitute\_mn инстаграмм хуудсыг эрхлэн явуулж байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэн нь өөрийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд цаашид судлаачдыг салбар эрх зүйгээр мэргэшүүлэн чадавхжуулах, судалгааны ажлын бүтээгдэхүүнийг эргэлтэд оруулах, эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангийн (www.legalinfo.mn) програм шинэчлэлтийг хэрэглээнд бүрэн нэвтрүүлэн, эрх зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажлыг олон нийтэд хүргэх ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна.

Албан хаагчдын ажлын байрны сэтгэл ханамжийн судалгааны хүрээнд албан хаагчдын компьютер, техник хэрэгсэл болон хэвлэх үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, найдвартай ажиллагааг хангах, агаар солилцоо, дулаалга, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх зэрэг шаардлага тулгарч байна.

### ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Тайланг нэгтгэж, үнэлсэн

*Б.Баасансүрэн*

Б.Баасансүрэн /ХҮШМ/

Тайлантай танилцаж,  
үнэлгээг хүлээн  
зөвшөөрсөн Захиргааны  
зөвлөлийн гишүүд:



Захирал:  
Х.Эрдэм-Ундрах

Эрдэмтэн нарийн бичгийн  
дарга:  
М.Түвшинжаргал

*[Signature]*

Захиргаа, удирдлагын  
хэлтсийн дарга:  
Э.Саранцэцэг

*[Signature]*